


КОВИД-19 халдварт цар тахлын эсрэг вакцинжуулалтад хамрагдсан иргэдийн 35.5 хувь нь өвчилжээ.

2021 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн амын 81.4 хувь бүрэн тунд хамрагдсанаас 73.9 хувь буюу 10 хүн тутмын 7 нь БНХАУ-ын VeroCell вакцин хийлгэсэн байна (Зураг 1).


Зураг 1. КОВИД-19 халдварын эсрэг вакцинд хамрагдалт, төрлөөр, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв

КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдлын 35.5 хувь нь КОВИД-19-ийн эсрэг аль нэг төрлийн вакцины нэгдүгээр болон бүрэн тунд хамрагдсаны дараа өвчилсөн байна. Тодруулбал, нэгдүгээр тунд хамрагдсаны дараа 7.6 хувь нь, хоёрдугаар тунд хамрагдсаны дараа 27.9 хувь нь өвчилжээ. Харин өвчилсөн иргэдийн 64.5 хувь нь огт вакцинд хамрагдаагүй иргэд байна (Зураг 2).


Зураг 2. КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдлын бүтэц, вакцинд хамрагдсан байдлаар, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв

Covishield (БНЭУ) вакцины бүрэн тунд хамрагдсан иргэдийн 6.8 хувь нь КОВИД-19-өөр өвчилсөн нь бусад вакцинтай харьцуулахад хамгийн өндөр байна. Харин манай улсын хүн амын ихэнх хувь нь БНХАУ-ын VeroCell вакцинд хамрагдсан бөгөөд эдгээр иргэдийн 1.9 хувь нь бүрэн тунд вакцинд хамрагдсаны дараа өвчилжээ (Зураг 3).


Зураг 3. КОВИД-19-ийн эсрэг бүрэн тунд хамрагдсан, өвчилсөн иргэдийн эзлэх хувь, вакцины төрлөөр



Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв

КОВИД-19 халдварын эсрэг вакцинд хамрагдаад өвчилсөн иргэдийг бүрэн тунд хамрагдсанаас хойш хоногоор авч үзэхэд 31 ба түүнээс дээш хоногийн дараа өвчилсөн иргэд дийлэнх хувийг эзэлж байна. Тодруулбал, тухайн вакцины бүрэн тунд хамрагдсанаас хойш 31 ба түүнээс дээш хоногийн дараа өвчилсөн иргэд Спутник вакцины хувьд хамгийн өндөр буюу 86.0 хувь бол AstraZeneca 76.3 хувь, Covishield 75.6 хувь нь байна. Харин 15-30 хоногийн дотор өвчилсөн иргэд VeroCell вакцинд хамрагдагчид хамгийн их буюу 22.2 хувь, 14 хоногийн дотор өвчилсөн иргэдийн эзлэх хувь Pfizer вакцины хувьд хамгийн их 32.3 байна (Зураг 4).


Зураг 4. КОВИД-19-ийн эсрэг бүрэн тунд вакцинд хамрагдаад өвчилсөн иргэд, вакцины төрөл, хамрагдсанаас хойш өвчилсөн хоног, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв


Вакцины бүрэн тунд хамрагдсан иргэдийн өвчилсөн хугацааг насны бүлгээр харахад 14 хоногийн дотор өвчилсөн иргэд 15-19 нас, 85-аас дээш насанд дунджаар 26.1 хувь буюу хамгийн их байна. 15-30 хоногийн дотор өвчилсөн иргэдийн эзлэх хувь 15-19 нас, 80-аас дээш насанд хамгийн их буюу дунджаар 28.0 хувь, бусад насны бүлгийн хувьд 45-аас дээш хоногийн хугацаанд өвчилсөн иргэд хамгийн их буюу дунджаар 38.9 хувь байна (Зураг 5).

Зураг 5. КОВИД-19-ийн эсрэг вакцины бүрэн тунд хамрагдаад өвчилсөн иргэд насны бүлэг, хамрагдсанаас хойш өвчилсөн хоног, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв

Зураг 6. КОВИД-19-ийн халдвараар нас барсан хүн, вакцинд хамрагдсан байдал, дүнд эзлэх хувиар



КОВИД-19-ийн халдвараар нас барагчдын ихэнх буюу 61.6 хувь нь вакцинд хамрагдаагүй, 20.7 хувь нь бүрэн тунд, 17.6 хувь нь I дүгээр тунд хамрагдсан байна (Зураг 6).

Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв